

лын үзэл суртлын удирдлагыг хүлээн дагаж буйг гэрчлэн харуулав. Их хурлын дараа манай нам коминтернд зөвлөх эрх бүхий талархагч секц болон элсжээ.¹² МАХН байгуулагдсан нь Монголын ард түмний эрх чөлөөний тэмцэлд эргэлтийн үе боллоо. 1921 оны ардын хувьсгалын ялалтаас өмнө Д. Сүхбаатар тэргүүтэй Монголын хувьсгалчид Зөвлөлт Оростой холбоо тогтоов.

Орос хэлнээс товчлон
орчуулсан Ч. Эрдэнэбаяр.

¹ **Майский И. М.** Монголия накануне революции», М., 1959. «История Монгольской Народной Республики (издание третье, переработанное и дополненное) М., 1983, **Пунцагноров Ц.** Монголын автономит үеийн түүх, 1955, **Б. Лигу.** Из истории русско-монгольских отношений в конце XIX-в начале XX в. (автореферат канд. диссер.), 1960. и др.

² **В. И. Ленин**, Полн. собр. соч., т. 30, с. 119

³ **В. И. Ленин**. Полн. собр. соч., т. 30, с. 120

⁴ **См. :Капица М. С., Иваненко В. И.** Дружба, завоеванная в борьбе, М.Международ. отношения, 1965, с. 13

⁵ Монгол Ардын Хувьсгалт Намын түүхийн зарим чухал баримтууд. УБ., 1946, с. 64—65

⁶ См.: ЦПА ИМЛ при ЦК КПСС, ф. 372, оп. 1, д. 31: л. 2

⁷ См.: Там же

⁸ См.: Там же

⁹ Партархив Иркутского ОК КПСС, ф. 1, оп. 1, д. 3, л. 2

¹⁰ Ленинский сборник. т. 35, М., Политиздат, 1945, с. 290

¹¹ «Общественные науки МНР», № 2, Улан-Батор, 1981, с. 49

¹² Некапиталистический путь развития и опыт Монгольской Народной Республики. М., Мысль, 1971, с. 72

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ АЮУЛ ЗАНАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Ш. САНДАГ

Түүхийн ухааны доктор

1980-аад дунд үеэр олон улсын харилцааг зааглан авч үзэх нь зүйтэй мэт бодогдоно. Учир нь ЗХУКН-ын XXVII их хурал, дэлхий ертөнцийг 2000 он гэхэд цөмийн зэвсгээс ангижруулах тухай Зөвлөлтийн санал, дунд болон ойр тусгалын пуужин устгах тухай Зөвлөлт-Америкийн гэрээ зэрэг томоохон үйл явдлууд гарсан нь шинэ сэтгэлгээний үр дүн бөгөөд дэлхийн түүхнээ шинэ зааг бий болголоо.

Дайн энхийн асуудлын үүднээс авч үзвэл олон улсын байдал ямагт хурцадсаар цөмийн дайны аюул босгон дээр тулж ирснийг сэрэмжлэн зайлуулж, буцааж хариулж болох юм гэдгийг 1980-аад оны дунд үе

үзүүлжээ. Иймд үүгээр зааглан Ази, Номхон далайн бүс нутгийн одоогийн олон улсын харилцааны эерэг, сөрөг талыг авч үзэх нь ойлгомжтой болно.

Улс төрийн газрын зураг дээр тоймлон харвал энэ бүс нутагт социализмын ууган орон-ЗХУ, дэлхийд хамгийн олон хүнтэй 1 миллиард 72,3 сая хүн амтай социалист Хятад, капиталист ертөнцийн хамгийн хүчтэй гүрэн-АНУ гурав оршиж байдаг билээ. Цөмийн зэвсэг бүхий эдгээр гурван гүрний байр суурь энэ бүс нутгийн өнгөрсөн түүх, өнөөдөр, ирээдүйд тодорхой ажээ. Өнөөдөр болон ирээдүйн тухай яривал, энэхүү гурван гүрэн ер нь их гүрнүүдийн харилцаа хэрхэн хөгжихөөс зөвхөн Ази, Номхон далайн бүс төдийгүй, дэлхий дахины байдал ихээхэн хамаарна. Нөгөө талаар, Ази тивд ч, бусад тивд ч тэр бусад улсууд, олон түмэн дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдал, хөгжил дэвшилд гүйцэтгэх роль үүрэг улам ихэсч байгаа бөгөөд үүнийг эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, цөмийн дайны эсрэг өргөн олон нийтийн хөдөлгөөн харуулж байна.

Дэлхийн улс төрийн бодлого, олон улсын амьдралд Ази, Номхон далайн бүс нутгийн гүйцэтгэх роль өдрөөс өдөр ирэх тутам их болж байна. Энэ бүс нутаг дэлхийн хүн амын ихэнх оршдог, өргөн уудам талбайтай стратегийн чухал газар, байгалийн баялагаар арвин их төдийгүй энд тогтсон улс төр, эдийн засгийн байдлаар тодорхойлогдоно.

ЗХУ-ын энэ талаархи байр суурийн тухай ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев өгүүлсэн нь: «Зөвлөлт Холбоот улс бол Европын төдийгүй, бас Азийн орон мөн бөгөөд иймээс ч ирэх зуунд дэлхийн улс төрийн бодлогын төв шилжин байрлах төлөвтэй Ази, Номхон далайн асар уудам бүс нутгийн байдлыг сайжруулж, бүх улсын эрх ашгийг харгалзан үзэж, тийм эрх ашгийг тэнцүүлэх үндсэн дээр харилцааг өөрчлөн байгуулахын төлөө тэмцэж байна. Энэ бүс нутгийг аль нэг этгээдийн эзэмшил газар байлгахыг бид эсэргүүцнэ. Бид үнэхээр тэгш эрхтэй байж харилцан ажиллаж, нийтээр аюулгүй байх саналыг бүх улсад тавьж байна»¹ гэжээ.

Ази, Номхон далайн бүс нутаг АНУ-ын неоглобалист номлол, Азийн стратегид онцгой байр эзлэж байна. АНУ-ын ерөнхийлөгч Рейган XXI зууныг «Номхон далайн эрин» гэж нэрлэсэн тал бий.

Америкийн милитарист этгээдүүд Номхон далайг «Америкийн нуур» мэт үзэж, тэнд дураар дургиж, зэвсэг хангинуулан, тэндэх улс түмний амгалан тайван байдлыг алдагдуулж, аж амьдралд нь хөнөөл учруулж, цөмийн дайны бэлтгэл шургуу хийж байна.

Ази, Номхон далайн бүс нутагт милитаричлах процесс маш хурдан явагдаж байна. Империализм, милитаризмын бодлого юунд хүргэж байгааг жишээлбэл, Ази, Номхон далайн бүс нутагт зэвсэг барьсан цэргийн тоо 17 сая буюу дэлхийн бүх армийн 2/3-ыг эзэлж байна. Эндэх улсуудын үндэсний бүтээгдэхүүнээс 560 миллиард доллар цэргийн зардалд үрэгдэж, 560 сая хүн өлсгөлөн гуйланчлалын хатуу зүдүүг² амсаж байна.

Өнөөдрийн Ази, Номхон далайн бүс нутагт империалист, харгис хүчний эзэрхийлэн түрэмгийлэх, өдөөн хатгах дайн дажинд бэлтгэх бодлогын уршгаар харилцан үл итгэлцэх, үл ойлголцох уур амьсгал нэлээд газар авч, зэвсгээр, юуны өмнө цөмийн зэвсгээр хөөцөлдөх, түүнийг турших явдал үргэлжилж, цэрэг-улс төрийн эвсэл холбоонуудаас зарим нь устсан боловч зарим нь хэвээр үлдэж, бас шинийг байгуулж

босгох хандлага ч гарч байна. Америкийн цэрэг, цэргийн баазууд энэ бүс нутгаар тархан ЗХУ ба социалист бусад орнуудыг тойрон хүрээлсэн хэвээр байна. Япон, Пакистан зэрэг улс милитаризмын замаар ороод шуударчээ. Пакистан, Израиль хоёр цөмийн зэвсэгтэй болох гэж мэрийж байна.

Бүс нутгийн хямрал Азид, бусад тивээс илүү олон бөгөөд ноцтой байна. Энэ тухай МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх дүгнэн хэлэхдээ: Энэхүү бүс нутагт бие биенээ үл итгэх уур амьсгал суулгаж, нутаг дэвсгэр, хил хязгаарын янз бүрийн маргааныг байнга өдөөн тухирч, сэргэлдөөнтэй байдлыг даамжруулахыг оролдсоор байгаа нь ерөнхийлөгч Рейганы тунхагласан Америкийн империализмын Дэлхийг ноёрхох шинэ бодлогын бүрэлдэхүүн хэсэг мөн»³ гэжээ.

Бүс нутгийн сэргэлдөөнөөс хамгийн ноцтой нь, жишээ нь, Ойрхи Дорнодын ужиг хямрал мөн бөгөөд улам ч хурцдаж, ерөөс намжих төлөв гарахгүй л хэвээр байна. Энэ бүс нутгийн хямрал гарсны учир шалтгаан нь империализм, сионизмын үзэл бодолтой холбоотой болохыг бодитой сэтгэгч хүн бүр мэднэ. Гэтэл Израильд түүнийг анх үүсгэн байгуулахад хамгийн түрүүнд тус дэмжлэг үзүүлсэн орны нэг-ЗСБНХУ дайсагнаж байгаа мэтээр харуулахыг империалист, сионист суртал нэвтрүүлэг оролдож байна.⁴

Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, мэдээж хэрэг, бүх дэлхийн аюулгүй байдалтай холбоотой боловч бүс нутгийнхаа хэмжээнд өөрийн онцлогтой ажээ. Тус бүс нутгийг олон улсын харилцааны түгшүүртэй байдлаас гаргахын тулд аятай нааштай бүхий л нөхцөл бололцоог холбогдох улсууд хамтын хүчээр бий болгох арга замыг эрэлхийлэх хэрэгтэй юм.

Үүний тул, тухайлан олон улсын харилцаанд, хуучин сэтгэлгээтэй зууралдах арга барил, заншил зуршлыг таягдан хаяж, шинэ сэтгэлгээнд шилжин орох нь чухал ажээ.

Ази, Номхон далайн бүс нутгийн тулгамдсан асуудлуудыг эв зүйгээр шийдвэрлэхийн тулд БНМАУ тодорхой саналаа дэвшүүлж, практик арга хэмжээ авсаар ирлээ. МАХН-ын XVIII их хурлаас Ази, Номхон далайн улсуудын хооронд үл довтолох, хүч үл хэрэглэх конвенц байгуулах, энэ талаар бүс нутгийн олон улсын бага хурал хуралдуулах тухай гаргасан санаачилга үүний дараа Азийн орнуудын өргөн олон нийтийн төлөөлөгчдийг оролцуулан энх тайван, хамтын ажиллагааны төлөө нийт Азийн чуулга уулзалт зохион байгуулах тухай, МАХН-ын XIX их хурлаас дэвшүүлсэн эдгээр санаа санаачилга Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын зүгээс дэмжлэг олсоор байна. Үүний нэг тод илрэл нь Улаанбаатар хотноо 1987 оны 7-р сард болсон Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын коммунист, ажилчны намын төлөөлөгчдийн зөвлөлдөх уулзалт мөн. Тус чуулга уулзалтад оролцсон 21 орны намын төлөөлөгчид БНМАУ-ын сүүлийн үед дэвшүүлсэн санаачилга, түүний явуулж буй тууштай энх тайванч гадаад бодлогыг зүй ёсоор үнэлсэн билээ. Мөн үүний өмнө 1984 онд Манила хотноо болсон Зүүн Ази, Номхон далайн районы энх тайвны бага хурлаас хүч үл хэрэглэх конвенц байгуулах, улс түмний энх тайван орших эрхийн тухай баримт бичиг баталсан, 1985 онд Сидней хотод зарлан хуралдуулсан Ази, Номхон далайн районы энх тайвны олон улсын бага хурлын Тунхаглалд манай Монголын санаачилгыг дэмжиж хэрэгжүүлэх нь

зүйтэй гэж тэмдэглэсэн зэрэг баримтуудаас үзвэл тус бүс нутгийн аюулгүйг сахин хамгаалж бэхжүүлэх зам дээр БНМАУ-ын санал нь энхийг эрхэмлэгч хүчний зүгээс дэмжлэг олж, тэдний тэмцэлтэй нийлж чухал хүчин зүйл болж байна. БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд М. Дүгэрсүрэн Япон, Австралид хийсэн албан ёсны айлчлал ч тус улс болон дээрх хоёр улсын хоорондын харилцан ойлголцох, харилцан ашигтай зарчмын үндсэн дээр хамтран ажиллах явдалд тодорхой хувь нэмэр оруулсан билээ. Ази, Номхон далайн аюулгүйн асуудлаар Монголын дэвшүүлсэн дээрх санал, авч буй арга хэмжээ нь энэ бүс нутгийн талаар баримталж буй ЗХУ-ын чиг шугамтай тохирч байна.

ЗХУ-ын ленинч гадаад бодлого даян дэлхий, түүний дотор Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж байна. Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх хэрэгт ЗХУ-ын сүүлийн үед дэвшүүлсэн санаачилга нь М. С. Горбачевын Владивостокт хэлсэн үг,⁵ Индонезийн «Мердека» сонин асуултад өгсөн хариу зэрэг баримт бичгүүдэд тусгалаа олжээ.

Зөвлөлтийн санаачилгын гол утга санаа нь тус бүс нутгийн тулгамдсан асуудлуудад иж бүрнээр хандаж, тэдгээрийг шийдвэрлэх хэрэгт холбогдох бүх улсуудыг оролцуулахад оршино. М. С. Горбачев «Мердека» сонинд өгсөн хариундаа «...Бид ЗСБНХУ энэ бүс нутгийн улсуудад аюул занал учруулах хүчин чармайлт тавьж байгаа мэт яриаг АНУ-ын зүгээс удаа дараа сонсож байгаа хэдий ч энэ оронтой хамтын ажиллагаа тогтооно гэж найдаж байна. Тийм яриа бол утгагүй зүйл. Бид бүх улсыг энх тайван, харилцан ойлголцооны эрх ашгийн үүднээс Ази, Номхон далайн бүс нутагт хамтран ажиллахыг урьж байна. Энэ тухай Владивостокт ч хэлсэн билээ»⁶ гэжээ.

ЗХУ-аас бүс нутгийн хямралыг арилгаж, улс түмний итгэлцэлийг бэхжүүлэх талаар баримталж буй тууштай чиг шугам нь Ойрхи Дорнодын байдал, Афганистаны эргэн тойрон бий болсон үйл явдлыг зохицуулах асуудал дээр тодорхой харагдаж байна.

Афганы асуудлыг улс төрийн аргаар зохистой шийдвэрлэж, тус оронд явагдаж буй үндэсний эвлэрлийн процесст дөхөм үзүүлэх үндсэн санаа ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачевоос Афганистаны талаар 1988 оны 2-р сарын 10-нд хийсэн мэдэгдэл,⁷ БНАФГУ-ын ерөнхийлөгч Нажибуллагийн 1988 оны 2-р сарын 9-ний мэдэгдэлд⁸ тодорхой тусгагдсан байна.

Израилийн түрэмгийлэгчдэд эзлэгдсэн бүх газрууд -Иордан голын баруун эрэг, Газын сектор, Зүүн Иерусалимд палестины ард түмний хүчтэй бослого өрнөж, израилийн зандалчид хайр найргүй аллага таллага явуулж, мөн иран-иракийн утга учиргүй дайн зогсох шинжгүй улам өргөжиж байгаа нөхцөлд Ойрхи Дорнодын асуудлаар олон улсын бага хурал хуралдуулах явдал чухлаар шаардагдаж байна. Дэлхий дээр бүс нутгийн сөргөлдөөн мөргөлдөөнийг зогсоох чигт ЗХУ, социалист бусад улс, шударга хүн төрөлхтөн их хүчин зүтгэж байна. БНМАУ Зүүн өмнөд Азийг энх тайван, хамтын ажиллагаа, аюулгүй бүс болгох тухай БНСВУ, БНАЛАУ, БНКАУ-ын санал, Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох тухай БНАСАУ-ын саналыг бүрнээ дэмжиж байна.

1980-аад оны дундуур дэлхий дахинд улс төрийн уур амьсгалыг сайжруулах, сэрэмжлэн зайлуулах, цөмийн зэвсэг хураах, улс түмний итгэлцлийг бэхжүүлэх зүгт онц чухал алхам хийлээ. Энэ бол ЗХУКН-

ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев АНУ-д 1987 оны 12-р сард хийсэн албан ёсны айлчлалын үеэр дунд болон ойр тусгалын пуужинг устгах тухай зөвлөлт-америкийн гэрээ байгуулсан явдал мөн.⁹

Орчин үеийн олон улсын харилцаанд шинэ сэтгэлгээ нэвтэрч эхэлж байгаагийн илэрхийлэл болсон М. С. Горбачев, АНУ-ын ерөнхийлөгч Р. Рейган нарын гарын үсэг зурсан энэ гэрээгээр олон улсын харилцааны түүхэнд эргэлтийн үе, цөмийн зэвсэггүй ертөнцийг цогцлон байгуулж болох боломжийг харуулсан шинэ үе нээгдлээ гэж үзэж болно. Цөмийн бүхэл бүтэн хоёр ангиллын пуужин устгах тухай Зөвлөлт-Америкийн энэхүү гэрээг бүх дэлхийн олон нийт гүн талархан халуунаар дэмжсэн билээ.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх Вашингтонд байгуулсан дээрх Зөвлөлт-Америкийн гэрээг өндрөөр үнэлж, 1988 оны босгон дээр Монголын ард түмэнд хандан радио, телевизээр хэлсэн үгэндээ: «Өнгөрч байгаа онд дэлхий дахинд түгшүүртэй байдлыг намжаах, зэвсэг хураах, цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулахад таатай нөлөө үзүүлсэн түүхэн чухал үйл явдлууд болж өнгөрлөө. Зөвлөлт-Америкийн дээд хэмжээний уулзалт болж, дунд болон ойр тусгалын пуужин устгах тухай гэрээнд гарын үсэг зурсан нь улс төрийн шинэ сэтгэлгээний томоохон ялалт, зэвсэг хураах зүгт хийсэн бодитой алхам боллоо. 1987 оны энэ чухал үйл явдал түүхийн он дарааллын хуудаснаа үүрд тэмдэглэгдэн үлдэх болно»¹⁰ гэж тэмдэглэжээ.

Дунд ба ойр тусгалын пуужин устгах тухай Зөвлөлт-Америкийн гэрээ тус хоёр их гүрэн - ЗХУ, АНУ-ын хоорондын ба олон улсын харилцааны түгшүүрийг намжаахад чиглэсэн нэн чухал алхам, эхлэл мөн боловч, энэ чигт хараахан үндсэн эргэлт гараагүй байна. Гэвч, олон улсын харилцааны нарийн түвэгтэй нөхцөлд М. С. Горбачевын хэлснээр, дөнгөж соёолж эхэлж байгаа энэ шинэ сэтгэлгээ, шинэ сэргэг үзэгдлийг нандигнан бэхжүүлж, бүх хүн өөрсдийн гараар цогцлон байгуулах зэвсэглэлгүй, хүчирхийлэлгүй ертөнцийн зүг алхам алхмаар ойртох хэрэгтэй аж. 1988 оны эхний хагаст товлосон Зөвлөлт-Америкийн дээд хэмжээний ээлжит уулзалтаар АНУ, ЗХУ-ын стратегийн давших зэвсэглэлийг 50 хувиар хорогдуулах тухай гэрээ байгуулахаар тохиролцсон нь олон улсын хурцадмал байдлыг намжаах бас нэг томоохон үйл явдал болох нь эргэлзээгүй.

Дунд болон ойрын тусгалын пуужин устгах тухай Зөвлөлт-Америкийн гэрээ нь цөмийн зэвсгийг «Дэлхий нийтийн хэмжээгээр давхар Тэглэх» учир зөвхөн Европт төдийгүй, бас Ази тивд шууд холбогдолтой юм. Учир нь, Ази, Номхон далайн бүс нутаг бол өнөөдөр цөмийн зэвсэг хуримтлагдсан байдлаар Европын дараа хоёрдахь байранд орж байгаа юм. Цөмийн хоёр ангиллын зэвсгийг устгах тухай Зөвлөлт-Америкийн гэрээ байгуулагдаж одоо хэрэгжиж эхэлж байгаа нь цөмийн дайны аюулыг багасгах, цөмийн зэвсгийг хорогдуулан устгахыг мөрөөдсөн хүн төрөлхтний итгэл найдвар биелэгдэж эхэлж, олон улсын байдал сайжирч байгаа хэрэг мөн. Гагцхүү энэ чигт бүх дэлхий даяар эрүүл саруул хүчийг нэгтгэн дайчилж империалист, милитарист хүчний харгайгаар дэлхий дахины байдал бүхэлдээ хурцадмал хэвээр үргэлжилж цөмийн дайны аюул занал арилаагүй байгаа өнөөгийн нөхцөлд дэлхийн

социализмын ролийг улам өндөржүүлж, социалист орнуудын найрамдал, хамтын ажиллагааг бүх талаар бэхжүүлж хөгжүүлэх явдал нэн чухал ажээ.

БНМАУ Азийн ууган социалист орны хувьд Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын найрамдалд харилцааг өргөтгөж, хамтран ажиллах явдлыг өрнүүлэх, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар ихээхэн хүч чармайлт тавьж байдаг билээ. БНМАУ энэ чигт юуны өмнө Азийн бусад социалист орон ЗХУ, БНХАУ, БНАСАУ, БНСВУ, БНАЛАУ, БНКАУ болон Энэтхэг зэрэг энхийг эрхэмлэгч бүх улсуудтай хамтран ажиллахыг эрхэмлэн үзэх гадаад бодлогоо тууштай явуулж байна.

¹ **М. С. Горбачев.** Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ. Манай оронд болон дэлхий дахинд. УБ., 1988., х. 221

² «Проблемы Дальнего Востока» 1987., No 6, с. 3

³ **Ж. Батмөнх,** Азийн аюулгүй байдалд нийтээр анхаарал тавья. «Энх тайван социализмын асуудал», 1987, No 6. х. 5

⁴ **М. С. Горбачев.** Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ. Манай оронд болон дэлхий дахинд. УБ. х. 212

⁵ **М. С. Горбачев,** Избранные речи и статьи Т. 4. М., 1987, с. 9—35

⁶ **М. С. Горбачев,** Индонезийн «Мердека» сонины асуудалд өгсөн хариулт. «Үнэн», 1987—7—24

⁷ Заявление Генерального секретаря ЦК КПСС М. С. Горбачева по Афганистану. «Правда», 1988. II—11

⁸ Заявление Наджибуллы. - «Правда» 1988. 11-10

⁹ Визит Генерального секретаря ЦК КПСС М. С. Горбачева в США. М., 1987, с. 32—61

¹⁰ **Ж. Батмөнх,** Монголын ард түмэнд хандаж радио, телевизээр хэлсэн үг. -«Үнэн», 1988—1—1

**ҮНДЭСНИЙ ЭВЛЭРЛИЙН
БОДЛОГО БОЛ АФГАНЫ АРД
ТҮМНИЙ ЭНХ ТАЙВАН
ХӨГЖЛИЙН ЗАМ МӨН**

М. ХУРМЕТХАН
Ж. ОЮУНСҮРЭН

1987 оны нэгдүгээр сард АААН-ын Төв Хорооны өргөтгөсөн онц бүгд хурал болж АААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Нажибуллагийн тавьсан «Нийт үндэсний эвлэрлийн бодлогыг хэрэгжүүлэхэд АААН-ын гүйцэтгэх зорилтын тухай» илтгэлд Афганистанд үндэсний эвлэрэл тогтоох бодлогыг зарлаж тунхагласан юм.

Эвлэрэл тогтоох зарчимд юуны түрүүнд «байлдааны гал зогсоох, Афганистаны одоогийн болон ирээдүйн асуудлыг шийдвэрлэсэн нөх-